



Хичээлийн сэдэв:

XX зууны монголын соёл



ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

XX зууны
Монголын
соёл

Монгол төрийн бэлгэдэл

Монголчуудын соёлын өөрчлөлт

Монголчуудын шашин шүтлэгийн уламжлал,
шинэчлэл

Монголын нүүдлийн иргэншлийн өөрчлөлт





ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

XX зууны Монголын соёлд гарсан чухал өөрчлөлтүүдийг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн залгамжаар танин мэднэ.



Харьцуулан
шинжлэх

Баримтыг
тайлбарлах

Түүхчлэх



ХХ ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ **ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ**



Төрийн бэлгэ тэмдэгт юу юу ордог вэ?

Тэдгээр нь юуг бэлгэддэг вэ?

Төрийн бэлгэ тэмдгээс юуг сайн мэдэх вэ?



XX ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ



1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал /цаашид "Төрийн бэлгэ тэмдэг" гэх/ мөн.

2. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.

Эх сурвалж: Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 2-р зүйл



XX ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ

ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ

Төрийн сүлд нь

- ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай,
- төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн,
- мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугираг хөх дэвсгэртэй байна.

Сүлдний төв хэсэгт Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна.

Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.

Үндсэн хуулийн 12-р зүйл.





XX ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ

ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ



1911 - 1924



1960-1992



1940-1949



1924-1940



1949-1960



1992 -



XX ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ

ТӨРИЙН ТУГ




Монгол Улс ардчилсан хөгжлийн замд шилжсэний дараа 1992 онд Цагаан тугийг шинээр бүтээн залж, **төр улс энх мөнх оршихын бэлгэдэл** болгон залжээ. Төрийн есөн хөлт Цагаан тугийг Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөнд байрлуулж жил бүрийн улсын их баяр наадмын өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд залж цэнгүүлэх ёслолыг гүйцэтгэдэг.



XX ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ

ТӨРИЙН ДАЛБАА



“Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо байрлуулна. Далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна.”

Үндсэн хуулийн 12-р зүйлийн 4 дэх хэсэгт



XX ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ

ТӨРИЙН ТАМГА



Шашин төрийг
хослон баригч,
Наран гэрэлт
Богд хааны
хаш эрдэнийн
тамга. 1911 он



Төрийн тамга нь Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар дөрвөлжин хэлбэртэй, голдоо Төрийн сүлдтэй сүлдний хоёр талаар Монгол Улс гэсэн бичээстэй, арслангийн дүрс бүхий бариултай байдаг.



Төрийн тамгыг Монгол Улсын Ерөнхийлөгч барьж, Монгол Улсын Үндсэн хуулийн уг эхийн хуудас бүр дээр, Монгол Улсын хууль, Улсын Их Хурлаар соёрхон баталсан олон улсын гэрээ, Монгол Улсаас гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийн уг эхийн эхний хуудас дээр тус, тус дардаг байна.



XX зууны монголын соёл

ТӨРИЙН ДУУЛАЛ

XIII Эртний сайхан

1930-аад оны үеэс дуулахаа больж мартагдаж байсныг 1936-онд алдарт дуучин **Магсар хурцын Дугаржав** уртын дууны түүвэр ном бичихдээ оруулсанаар дууны үг нь хадгалагдан үлджээ.

Олноо өргөгдсөн улсын үед **"Зуунлангийн жороо луус"** дуу төрийн сүлд дуулал болж байв.

1950 онд шүлгийг Ц. Дамдинсүрэн
Аяыг Б. Дамдинсүрэн, Л. Мөрдорж

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 43-р зарлигаар батлав.



XX ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ

ХҮН АМЫН СОЁЛЫН ТҮВШИН





ХХ ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ

ХҮН АМЫН СОЁЛЫН ТҮВШИН



1950 онд нэг хүн жилд дунджаар нэг кино үзэж байсан бол 1960 онд 5 удаа кино үзэх болсон.



1960-д оны байдлаар 30 сонин, 20 сэтгүүл гарах болж, тэдгээрийн хэвлэгдэх хувь өсөж, гурван хүн тутамд 2 тогтмол хэвлэл ногдох болсон.



1960-д оны байдлаар 10.000 хүнд оногдох эмнэлгийн ор 81, их эмч 9.7 хувь болж өсчээ.



XX ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ

ХҮН АМЫН СОЁЛЫН ТҮВШИН



1960 онд 5.4 сая хүн ямар нэгэн үзвэр үзсэн бол 1985 онд 28.6 сая болж үзвэр үзэгчдийн тоо 5.3 дахин нэмэгдсэн.



Нийтийн номын сангийн гүйцэтгэх үүрэг дээшилж, уншигчдад номоор үйлчлэх арга хэлбэр өргөжив.



Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл соёлын үнэт зүйлийг дамжуулах төдийгүй өөрийн өнгө аяс бүхий соёлын үнэт зүйлсийг үйлдвэрлэгч болов.



XX ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ

МОНГОЛЧУУДЫН ШАШИН ШҮТЛЭГ

XX зууны эхэн гэхэд Халх дөрвөн аймгийн 80 гаруй хошууны нийт 750 орчим сүм хийдэд 115 мянга орчим лам шавилан сууж, тэдгээр сүм хийд нь аажмаар суурин амьдралтай төвүүд болон хувирч гар үйлдвэрлэл, арилжаа, худалдаа үйлчилгээний газрууд болон хөгжжээ.



1937 онд их хэлмэгдүүлэлт эхэлж 17 мянга гаруй ламыг баривчлан гурван анги болгон хувааж ял шийтгэл оногдуулжээ.



БНМАУ-д шашин шүтэх явдал хаалттай байсан бөгөөд Сайд нарын Зөвлөлийн хурлын шийдвэрээр 1944 онд Гандантэгчэглин хийдийн үйл ажиллагааг сэргээж, хурал ном хурахыг зөвшөөрсөн боловч МАХН-ын хатуу хяналтын дор үйл ажиллагаа явуулж байв.



1990 онд Ардчилсан хувьсгал ялснаар буддын шашин дахин мандан дэлгэрэх, сүсэгтэн олон бурхан шашнаа чөлөөтэй шүтэх боломж бүрдсэн юм.

Эх сурвалж: <https://mongoltoli.mn/history/h/843>



XX зууны монголын соёл

МОНГОЛЧУУДЫН ШАШИН ШҮТЛЭГ



СҮМ ХИЙД, 2018 оны байдлаар



нийт 1552 лам санваартан





XX зууны монголын соёл

Нүүдлийн иргэншил



- ❑ Эх газрын эрс тэс уур амьсгалтай, тал нутаг зонхилсон Төв Азийн бүс нутагт нүүдлийн мал аж ахуйг бий болгож,
- ❑ Түүнийг эрхлэн хөтлөх арга ухааныг бий болгон, өнөөг хүртэл унаган хэлбэрээр хадгалан хөгжүүлж ирсэн ард түмэн билээ.



XX ЗУУНЫ МОНГОЛЫН СОЁЛ

НҮҮДЛИЙН ИРГЭНШИЛ



Солонгосын гэрэл зурагчин Даэсунг Ли Монгол улсын газар нутгийн цөлжилт аюултай түвшинд хүрч буйг гэрэл зурагт буулган “Ирээдүйлэг археологи” нэртэй гэрэл зургийн цувралдаа оруулжээ.



АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА.